

**ТҮНЭЛ СУМАНД ГАЗАР ЭЗЭМШҮҮЛЭХ ТСӨЛ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД
МАЛЧДЫН ХОРШООГ ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА.**

Нэг: Төсөл сонгон шалгаруулах тухай үндсэн мэдээлэл

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах явуулах журам, 2024 оны 187 тогтоолоор батлагдсан “Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” журам, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны “2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 04 дүгээр тогтоол, сумын Засаг даргын **2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/40 дүгээр** захирамжаар дараах газрыг төсөл сонгон шалгаруулах журмаар шийдвэрлэхийг зөвшөөрсөн.

1.1 Төсөл сонгон шалгаруулалтаар шийдвэрлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, эзэмшүүлэх хугацаа

№	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Эзэмшүүлэх газрын байршил	Хэмжээ м.кв	Зориулалт	Эзэмшүүлэх хугацаа
1	4091787	Олны өтөг	2503	Мал аж ахуйн үйлдвэрлэл	15 жил
2	4091786	Олны өтөг	2506	Мал аж ахуйн үйлдвэрлэл	15 жил
3	4091753	Эрдэнэт	49573	Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил
4	4091748	Эрдэнэт	50000	Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил
5	4091752	Бийж	50000	Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил
6	4091751	Бийж	50000	Мал аж ахуйн үйлдвэрлэл, тэжээлийн ургамал тариалах	15 жил

1.2 Төсөл сонгон шалгаруулалтанд оролцогчдыг бүртгэх болон төсөл ирүүлэх хугацаа:

2024 оны 09 дугаар сарын 17-ны өдрөөс 2024 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн 18:00 цаг хүртэл төсөл хүлээн авна.

1.3 Төслийг хүлээн авах газрын тодорхой хаяг, харилцах утасны дугаар:

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Засаг даргын тамгын газар 203 тоот харилцах утасны дугаар: 99679251

1.4 Төсөл шалгаруулах хугацаа: 2024 оны 09 дүгээр сарын 25-наас 26-ны өдрийн 9⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд явагдана.

Хоёр: Төсөл сонгон шалгаруулалтанд оролцох малчдын хоршоо нь дор дурдсан тавигдах шаардлагыг хангасан байвал зохино.

№	Тавигдах шаардлага	Тайлбар
1.	Төслийн үйл ажиллагааны чиглэл нь нийцсэн эсэх;	Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журмын 11.1-т заасан үйл ажиллагааны чиглэлд нийцсэн байх.
2.	Улсын тэмдэгтийн хураамж	Төсөл сонгон шалгаруулалтад оролцогч

	төлсөн эсэх;	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.6-д зааснаар тэмдэгтийн хураамж 12500 төгрөгийг төрийн сан 100171300941 дансанд төлсөн байх.
3.	Төслийн иж бүрдлийг хангасан эсэх; 1. Хоршооны гэрчилгээ 2. Хоршооны дүрэм 3. Төслийг хоршооны эрх бүхий этгээд баталгаажуулсан эсэх	Төсөл сонгон шалгаруулалтын иж бүрдэлд хоршооны гэрчилгээ, хоршооны дүрмийн хуулбарыг ирүүлж, төслийг хоршооны эрх бүхий этгээд баталгаажуулсан байдлыг дүгнэнэ. Ажлын хэсэг төсөл тус бүр холбогдох зард заасан бүрдлийг хангасан эсэхийг шалгана. Зард заасан баримт бичиг бүрдэл дутуу тохиолдолд Ажлын хэсэг энэ тухай оролцогчид мэдээлж, тухайн үзүүлэлтээр үнэлгээ өгөхгүй байх, эсхүл төслийг сонгон шалгаруулалтаас хасах шийдвэр гаргана.
4.	Төслийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулсан эсэх;	Төслийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500 стандартын дагуу боловсруулсан эсэхийг үнэлж дүгнэнэ.
5.	Ажиллах хүчний болон техник технологи, тоног төхөөрөмжийн чадавх, нөөцтэй байх;	Тухайн төслийг хэрэгжүүлэх ажиллах хүчний болон техник технологи, тоног төхөөрөмжийн чадавх, нөөцтэй эсэхийг харгалзан үзнэ.
6.	Шинээр бий болох ажлын байрны тоо, хэмжээ;	Төсөл хэрэгжүүлснээр тухайн сум, орон нутагт шинээр бий болох ажлын байрны тоо, хэмжээг харгалзан үзнэ.
7.	Нийгэм, эдийн засгийн хөгжилд ач холбогдолтой эсэх;	Төсөл хэрэгжүүлснээр тухайн сум, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд ач холбогдолтой байдлыг харгалзан үзнэ.
8.	Улс, орон нутгийн төсөвт оруулах орлогын хэмжээ;	Улс, орон нутгийн төсөвт орох татварын болон татварын бус орлогын хэмжээг харгалзан үзнэ.
9.	Байгаль орчинд ээлтэй байдал	Төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчныг хамгаалах, хүн, амьтны аюулгүй нөлөө үзүүлэх байдлыг харгалзан үзнэ.

ТҮНЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР